

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БИЕЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 04 сарын 26 өдөр

Дугаар А/13


Сүмбэр сум

Ажил хавсран гүйцэтгэх тухай

Монгол улсын төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 311 дугаар тогтоол, Биеийн тамир спортын улсын хорооны даргын 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/121 дугаар тушаал, Говьсүмбэр аймгийн Биеийн тамир спортын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний 8 дугаар зорилтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын үйл ажиллагаа болон спортын салбар холбоодын үйл ажиллагаанд “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.
2. Биеийн тамир спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах албаны дарга М.Батдэлгэрт байгууллагын дотоод хяналт шалгалтын ажлыг хавсран гүйцэтгэхийг даалгасугай.
3. Байгууллагын дотоод хяналт шалгалтын талаар мэргэжлийн хяналтын газар, дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээ, аудитын хэлтэстэй хамтран ажиллах, улирал бүр тайлан гаргаж байхыг дотоод хяналт шалгалтын ажилтан /М.Батдэлгэр/-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *М.Батдэлгэр* Б.БУЯНТОГТОХ



Биеийн тамир спортын газрын даргын
2021 оны 07 дугаар сарын 14 өдрийн
А/13 тоот тушаалын хавсралт



БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН СПОРТЫН САЛБАР ХОЛБООД ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг: Нийтлэг үндэслэл

Энэхүү нийтлэг журмын зорилго нь байгууллагын болон спортын салбар холбоодын хэмжээнд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Төрийн хяналт шалгалтад хамрагдах өмчийн байгууллага /цаашид "байгууллага" гэх/ энэхүү нийтлэг журмыг дагаж мөрдөнө.

Байгууллага нь энэхүү нийтлэг журам нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "Дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам"-тай байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгж, байгууллагын "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах"-ыг Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 7.2, 8.2.1-д заасны дагуу дараахь эрх бүхий этгээд батална.

Энэхүү журмын 1.4-т зааснаас тохиолдолд "Дотоод шалгалтыг зохион байгуулах журам"-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө.

Байгууллага нь дотоод хяналт шалгалтыг зохион байгуулахдаа энэхүү нийтлэг журам болон Монгол улсын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтнаас нийтээр загаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг удирдлага болгоно.

Хуульд өөрөөр заагаагүй бол аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт-шинжилгээ, үнэлгээ/мониторинг/ энэхүү нийтлэг журам хамаарахгүй.

Хоёр. Дотоод хяналт, шалгалтын үйл ажиллагааны зорилго

2.1 Хяналт, шалгалтын үйл ажиллагаа нь салбарын хөгжлийн бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг хийх, эрсдэлийн удирдлагаар хангаж, тухай байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

Гурав: Дотоот хяналт шалгалтын үйл ажиллагааны зарчим, хамрах хүрээ

3.1 Баримтлах зарчим

3.1.1. Дотоод хяналт шалгалт нь хууль дээдлэх, хараат бус байж, ил тод, бие даасан, хяналт, шалгалтын дүнг бодитой, үнэн зөв, шударгаар тайлагнах, багаар ажиллах зарчимд тулгуурлана.

3.2 Хамрах хүрээ

3.2.1 Байгууллагын үйл ажиллагаа, иргэдэд үзүүлж байгаа ажил, үйлчилгээ нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтны болон өөрийн гаргасан шийдвэрт нийцэж байгаа эсэхэд аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд хяналт тавьж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, гэм буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэхэд чиглэнэ.

3.2.2. Зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр санхүүжилт авч, хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллагуудад хяналт, шалгалт хийнэ.

3.2.3. Дотоод хяналт шалгалт зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, байгууллагын үйл ажиллагааг бүрэн хамарсан байвал зохино.

Дөрөв: Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах ажилтан, түүний эрх үүрэг.

4.1. Энэхүү журмын 1.3-т заасан "Дотоод хяналт шалгалтын зохион байгуулах журам"-д өөрөөр заагаагүй бол дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах үүргийг тухай байгууллагын захиргааны асуудал хариуцсан ажилтан /цаашид "Дотоод хяналт шалгалтын ажилтан" гэх/ гүйцэтгэнэ.

4.2. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь тухай байгууллагын удирдлагад шууд захирагдах бөгөөд зохион байгуулалтын хувьд бусадд бүтэц, нэгжээс хараат бус байна.

4.3. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь тухайн байгууллагын эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлээр боловсрол, мэргэжил эзэмшиж мэргэшсэн, ажлын дадлага туршлагатай байна.

4.4. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь тухай байгууллагын болон спортын салбар холбоодын үйл ажиллагааны онцлог, үйлчилгээний чиглэл, хэмжээ, зохион байгуулалтын бүтэц зэргийг харгалзан тухайн жилд хийх хяналт шалгалтын ажлын тусгайлсан төлөвлөгөөг боловсруулан эрх бүхий албан тушаалтнаар батлуулан мөрдөж ажиллана.

4.5. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь хяналт шалгалтын ажлын дүн, авсан арга хэмжээний талаар улиралд нэгээс доошгүй удаа тухай байгууллагын удирдлагын хурлаар хэлэлцүүлж, шаардлагатай бол шийдвэр гаргуулан хамт олонд мэдээлнэ. .

4.6. Дотоод хяналт шалгалтын ажилтан нь эрх бүхий албан тушаалтны баталсан удирдамжийн дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэнэ.

4.7 Дотоод хяналт шалгалтын ажилтан нь дараахь нийтлэг эрх, үүрэгтэй байна.

4.7.1 Зохих удирамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах:

4.7.2 Хяналт шалгалтыг явуулахдаа байгууллагын алба, удирдлагатай шууд харилцаж, тэдгээрээс шаардлагатай мэдээ, судалгаа гаргуулах, холбогдох ажилтны ажлыг шалгаж танилцах, илэрсэн зөрчил, дутаглыг талаар тайлбар гаргуулах.

4.7.3 Илэрсэн зөрчил, дутагдлыг шалтгаан нөхцөлийг тодруулан зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх талаар арга хэмжээ авах.

4.7.4 Шаардлагатай бол илэрсэн зөрчил, дутагдлыг шалтгаан нөхцөлийг арилгах, асуудлаар болон зөрчил гаргасан этгээдэд хариуцлага ногдуулах талаар байгууллагын удирдлагад санал тавьж шийдвэрлүүлэх.

4.7.5 Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актыг өөрийн байгууллагад сурталчлах, хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулах:

4.7.6 Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчлийг арилгах, урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөгөх.

4.7.7 Холбогдох дүрэм, журам, байгууллагын стандартыг боловсронгуй болгох талаар судалгаа, дүгнэлт гаргах.

4.7.8 Дотоод хяналт шалгалтын үр внөлөө болон мэргэжлийн чадавхийг дээшүүлэх зорилгоор хөндлөнгийн хяналтын байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, зөрчлийг нь арилгаж чадахгүй асуудлыг хууль хяналтын эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, хамтран ажиллах талаар санал боловсруулан удирдлагад танилцуулах:

4.7.9 Байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын хэрэгжилт болон зөрчлийн талаархи мэдээллээр удирдлагыг хангах:

4.7.10 Хийсэн хяналт шалгалтын талаар бүртгэл хөтөлж, мэдээллийг сан бүрдүүлэх.

4.7.11 Дотоод хяналт шалгалтаар хүний амь нас, эрүүл мэнд, нийгэм болон хүрээлэн байгаа орчны аюулгүй байдалд шууд буюу шууд бусаар ноцтой аюул, хор хохирол учруулж болохуйц нөхцөл байдал үүссэн нь тогтоогдвол түүнийг арилгах арга хэмжээг нэн даруй авах, эрх бүхий байгууллагад мэдэгдэх:

4.8. Энэхүү журмын 3.7-д зааснаас бусад эрх, үүргийг тухайн байгууллагын "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-д тусгана.

4.9. Энэхүү журмын 3.7-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дотоод хяналт шалгалтын ажилтанд аливаа дарамт, шахалт үзүүлэх, үйл ажиллагаанд нь хөндлөнгөөс нөлөөлөхийг хориглоно.

Тав: Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагаа

5.1 Дотоод хяналт шалгалтыг дараахь чиглэлээр зохион байгуулна.

5.1.1 Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон эрх зүйн актын хэрэгжилт болон тухай байгууллагын хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтэнд тавих хяналт шалгалт:

5.1.2 салбар холбоодын спортын сургалт дасгалжуулалтын үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт

5.1.3 Салбар холбоодын спортын тэмцээн уралдааны зохион байгуулалт, чанарт тавих хяналт шалгалт

5.1.4 Усан спорт сургалтын төвийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт

5.1.5 Байгууллагын төсөв, санхүүгийн зарцуулалтанд тавих хяналт шалгалт

5.1.6 Спортын тэмцээн уралдааны төсөв, хуваарилалтанд тавих хяналт шалгалт

5.1.7 Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага, дотоод журмын биелэлтэнд тавих хяналт шалгалт

5.1.8 Өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалтанд тавих хяналт шалгалт

5.1.9 Байгууллагын "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг тухайлан заасан бусад хяналт шалгалт:

5.2 Энэхүү журмын 5.1 заасан чиглэлээр дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах хэлбэрийг тухай байгууллагын "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-аар зохицуулна.

Тав:Хариуцлага

5.1 Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын дагуу буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод журамд заасан хариуцлагыг ногдуулна.

5.2 Шалгалтаар үр дүнг санаатайгаар буруу мэдээлж тайлагнасан, хөндлөнгийн этгээдийн болон хувийн ашиг сонирхолд автаж алдаа, зөрчил, шамшигдлыг нуун дарагдуулсан болон хууль тогтоомжоор хориглосон, албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй үйлдлийг гаргасан шалгалтын багийн гишүүдэд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн дотоод журам болон байгууллагын холбогдох бусад дүрэм, журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

5.3 Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал нь гэмт хэргийн шинжтэй бол асуудлыг хуулийн байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.